



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/601

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/546 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багахангай дүүрэгт “Хот тохижилтын зориулалтаар дугуйт экскаватор худалдан авах” БХД-17/19 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан “Бадрангуй-орших” ХХК-аас нийлүүлэх хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн техникийн үзүүлэлт, шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалган хүлээн авч, Багахангай дүүргийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т актаар хүлээлгэн өгч, данс бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, хөрөнгө хүлээлцсэн акт бусад баримт бичгийг бүрдүүлэн холбогдох байгууллага, архивт хүлээлгэн өгөхийг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д.Рэнцэнбямбад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

2019.12.18

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 18 өдрийн 01/601 дугаар тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч	С.Ариунжаргал	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Хүрэлбаатар	Багахангай дүүргийн ЗДТГ-ын Хот тохижилтын хэлтсийн дарга
	Г.Одонбаатар	Багахангай дүүргийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхгэрэл	Багахангай дүүргийн Хот тохижилтын алба ОНӨААТҮГ-ын дарга
Нарийн бичгийн дарга	Н.Болормаа	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн